



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
2018 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: САГ-2019/21/СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.



Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх  
аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер Г.Гүнжидмаа  
Утас: 261885 Цахим хаяг: [gunjidmaag@audit.gov.mn](mailto:gunjidmaag@audit.gov.mn)  
Аудитор Ж.Болормаа  
Утас: 261628 Цахим хаяг: [bolormaaj@audit.gov.mn](mailto:bolormaaj@audit.gov.mn)  
Аудитор Э.Энхбаатар  
Утас: 261628 Цахим хаяг: [enkhbaatare@audit.gov.mn](mailto:enkhbaatare@audit.gov.mn)

Улаанбаатар хот  
2019 он

**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	2
2	Аудитын тайлан .....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.8.1	Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл .....	8
2.8.2	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудад хийсэн аудитын дүнгийн талаар.....	9
2.8.3	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.11	Шилэн дансны мэдээлэл .....	11
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Менежментийн захидал.....	12
3.1	Томилолтын зардалтай холбоотой .....	12
3.2	Давсан орлогын зарцуулалт.....	13
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
4.1	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	14
4.2	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	15
4.3	Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	16
4.4	Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	18
5	Хавсралт.....	19
5.1	Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт.....	19

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХХҮХ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА Б.НЯМДАВАА  
ТАНАА

2019.03.25 № 01/565  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт


Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



## Үүрэг хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Е.ОЮУНБИЛЭГ

## 2 Аудитын тайлан

### 2.1 Оршил

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Б.Нямдаваа Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 03 дугаар сарын 05-наас 03 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Ж.Болормаа, Э.Энхбаатар нар хэрэгжүүлэв.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/259 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын талаарх мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь “Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, нийгмийн халамжийн үйл ажиллагааны төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар иргэдийг ажилтай, орлоготой болгох, ядуурлыг бууруулах, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын үйл ажиллагааг чанаржуулах, Монгол хүний амьдралын чанарыг сайжруулахад оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь үйл ажиллагааныхаа чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүн амын хөдөлмөрлөх эрхийг хангах боломж, нөхцөлийг бүрдүүлж, ажиллах хүчний мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх замаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэн зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж ядуурлын түвшинг бууруулах.
- Үндэсний хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйлчилгээний бодлогын хэрэгжилтийг дэлхийн жишигт хүргэн хөгжүүлэх.
- Нэг цонхны бодлогоор Монгол Улсын иргэдийн дотоод, гадаадын мэргэшсэн хүний нөөцийн зах зээлд гарах гарц нь болох.
- Төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй, тэгш шударга, чанартай хүргэх чадварыг байнга дээшлүүлсэн суралцагч байгууллагыг хөгжүүлэх, стратегийн төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын чадамжийг дээшлүүлэх.

- Байгууллагын гадаад, дотоод харилцааг хөгжүүлж салбарын бодлогыг хэрэгжүүлэх, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх талаар хамтран ажиллах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх.
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний цахим мэдээллийн нэгдсэн сүлжээг боловсронгуй болгож, төрийн зохих байгууллагуудын сүлжээ, мэдээлэлтэй нэгдмэл байдлыг хангах.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
- Нийгмийн халамжийн тухай хууль
- Ахмад настны тухай хууль
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь нягтлан бодох бүртгэлийн "Acolous" програм хангамж ашигладаг байна.



Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Хяналт мониторингийн газар 11 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийжээ. Дараах чиглэлээр дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээ хийж нийт 261.4 сая төгрөгийн зөрчил илрүүлж, хэрэгжилтийг хангуулж ажиллажээ. Үүнд:

- Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ
- Байгууллагын дотоод үйл ажиллагааны хүрээнд
- Төсвийн үйл ажиллагааны хүрээнд
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн үйл ажиллагааны хүрээнд
- Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад
- Өргөдөл гомдлын талаар

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой санхүүгийн үр дүнгийн тайлангийн орлого, зарлага өссөнтэй холбоотой юм.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2018 оны нийт зардал 25,000.3 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 500.0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь төлөвлөлтийн шатанд тодорхойлсон хувийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 33 байгууллага, нэгжийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийж баталгаажуулахаас 30 байгууллага аудитад хамрагдсан байна.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Аудитын түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	29	1	3	0
	<b>Дүн</b>	29	1	3	0

Аудитад хамрагдсан төсвийн шууд захирагчдын 30 санхүүгийн тайлангаас “Зөрчилгүй” 26, “Хязгаарлалттай” 3 санал дүгнэлт авснаас 5 санхүүгийн тайланд гэрээгээр аудит хийлгэсэн байна.

### 2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт илэрсэн алдаа, зөрчлийн 46.6 хувь буюу 1,437.8 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 0.3 хувь буюу 7.0 сая төгрөгийн зөрчилд хохирлыг барагдуулах төлбөрийн акт тогтоож, 28.4 хувь буюу 312.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 24.7 хувь буюу 172.6 сая төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

/сая төгрөг/

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТТЗ	3	75.4	1	0.7			2	74.7				
2	ТШЗ	51	416.5	8	6.3	14	312.3	29	97.9				
	<b>Дүн</b>	<b>54</b>	<b>491.9</b>	<b>9</b>	<b>7.0</b>	<b>14</b>	<b>312.3</b>	<b>31</b>	<b>172.6</b>				

### 2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудад хийсэн аудитын дүнгийн талаар

Дорнод аймаг, Налайх дүүргийн ХХҮХ-үүд нь бараа материалын тооллого хийгээгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, БНСУ дахь Нэг цэгийн хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн ажлаас чөлөөлөгдсөн хүмүүстэй холбоотой түрээсийн байрны барьцааны авлага байгаа зэрэг зөрчлийг арилгах 15 албан шаардлага өгч, Дорноговь, Говь-Алтай, Дундговь, Ховд аймаг, Нийслэлийн ХХҮХ-үүд ажилчдын цалин, ур чадварын нэмэгдэл зөрүүтэй бодож олгосон, цалингаас татварын суутгал хийгээгүй зэрэг шалтгаанаар 8 төлбөрийн акт тогтоож, төсвийг бодитой төсөвлөх, батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн бүлэг хооронд гүйлгэн зарцуулахгүй байх зэрэг 29 зөвлөмжүүд өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын хугацаанд ХХҮЕГ-ын 2018 оны санхүүгийн тайланд түүврээр аудит хийсэн болно.

### 2.8.3 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 16 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд тусгаж, бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

#### Асуудал 1: Санхүүгийн тайлангийн залруулга

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт үр дүнгээс өмчийн өөрчлөлтийн тайлангийн тайлант үеийн үр дүнг 1,063.6 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Шийдэл: Аудитын явцад залруулсан.

## **Асуудал 2: Цалингийн урамшуулал**

ХХҮЕГ-ын даргын 2018 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн А/194 дүгээр тушаалаар 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар Хязгаарлалттай санал дүгнэлт болон зөрчил арилгах албан шаардлага авсан ХЭДС-гийн нягтлан бодогчид 0.7 сая төгрөгийн урамшуулал олгосон нь Сангийн сайдын 2006 оны 292 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнах журам”-ын “1.1. ... төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудын ажлын үр дүнг үнэлж, шагнаж урамшуулахад энэ журмыг мөрдлөг болгоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдэл: Төлбөрийн акт тогтоосон.

### **2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Орхон аймгийн ХХҮХ-ээр дамжуулан хэрэгжиж байгаа Нэг өрх-нэг ажлын байр хөтөлбөрийн хүрээнд 2017-2018 онд нийт 63 иргэнд 151.0 сая төгрөгийн зээл олгож тайлант оны эцэст 109.4 сая төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байна.

Тус хөтөлбөрийн санхүүжилт болон зээл олголт нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн дансаар бус ХХҮХ-ийн үйл ажиллагааны нэмэлт санхүүжилтийн дансаар дамжин хийгдэж байгаа нь төсвийн байгууллагын үйл ажиллагааны чиглэлтэй нийцэхгүй байна.

### **2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой 2018 онд 8 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 21,597.2 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн орлогын төлөвлөгөө 1,613.2 сая төгрөг, гүйцэтгэл 1,852.3 буюу 239.0 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө давж биелсэн ба зардлын нийт гүйцэтгэл 21,249.3 сая төгрөг буюу 98.4 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал хэмнэгдсэнээс шалтгаалжээ.

## **2.11 Шилэн дансны мэдээлэл**

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь шилэн дансны вебсайтад холбогдох мэдээллийг оруулдаг ба тайлант хугацаанд нийт оруулах мэдээллээс 2 төрлийн мэдээллийг улирлын дүнгээр хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 97.5 хувьтай байна. Үүнд,

Дорнод, Төв, Ховд аймгуудын болон Налайх дүүргийн ХХҮХ, ХХҮЕГ-ын өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй, анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Томилолтын зардалтай холбоотой**

##### **3.1.1 Илрүүлэлт**

Тайлант хугацаанд гадаад болон дотоод албан томилолтод нийт 95.6 сая төгрөг зарцуулснаас томилолтын зорилгод хамааралгүй албан тушаалтан явуулсан, нэг чиглэлд олон удаагийн томилолт гарсан, БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар явж буй иргэдийг хүргэж өгөхөөр Сангийн яам болон бусад аймаг нийслэлийн харьяа газруудын дарга нар томилолтоор явсан зэрэг 10.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

## **3.2 Давсан орлогын зарцуулалт**

### **3.2.1 Илрүүлэлт**

Өмнөх оны давсан орлогын авлагаар тооцож төвлөрүүлсэн 80.3 сая төгрөгийг өөрийн хөрөнгө оруулалтад зарцуулалгүй 64.0 сая төгрөгийн үнэ бүхий Ниссан тийна маркын автомашин худалдан авч ХНХЯ-нд шилжүүлсэн байна.

### **3.2.2 Эрсдэл:**

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах

### **3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3.4-д “тухайн салбар болон байгууллагын үйл ажиллагааг дэмжих зориулалт бүхий хөрөнгө оруулалт хийх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

### **3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 09 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,764,060.2	2,044,148.7
МӨНГӨН ХӨРӨНГӨ	14,838.6	47,516.1
АВЛАГА	609,223.7	724,930.4
УРЬДЧИЛГАА	1,851.4	2,177.8
БАРАА МАТЕРИАЛ	1,138,146.4	1,269,524.4
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	26,435,686.3	35,900,941.5
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	26,435,686.3	35,900,941.5
Биет хөрөнгө	26,121,121.6	30,401,133.5
Биет бус хөрөнгө	314,564.7	5,499,808.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	28,199,746.5	37,945,090.2
НИЙТ ӨР ТӨЛБӨР	28,003.1	4,136.1
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	28,003.1	4,136.1
Өглөг	28,003.1	4,136.1
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	28,171,743.4	37,940,954.1
Засгийн газрын хувь оролцоо	28,171,743.4	37,940,954.1
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	9,997,522.3	14,418,413.3
Хуримтлагдсан үр дүн	16,841,098.7	18,665,520.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,333,122.4	4,857,020.1
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	28,199,746.5	37,945,090.2



#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	32,904,296.6	33,217,123.2
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,385,832.4	11,233,957.5
Нийтлэг татварын бус орлого	7,385,832.4	11,233,957.5
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	25,518,464.2	21,983,165.7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	31,794,088.7	27,097,322.3
УРСГАЛ ЗАРДАЛ	31,794,088.7	27,097,322.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	280,80,717.9	25,207,488.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,390,851.8	14,903,657.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,573,670.5	1,749,849.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,441,506.5	1,704,540.2
Хангамж, бараа материалын зардал	2,968,293.3	1,421,035.3
Нормативт зардал	640,158.1	682,255.8
Эд хогшил, урсгал засварын зардал	242,578.0	219,438.2
Томилолт, зочны зардал	486,584.4	161,544.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,129,350.1	1,360,442.4
Бараа үйлчилгээний бусад зардал	4,207,725.1	3,004,725.3
ХҮҮ		
ТАТААС	7,952.0	0.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,705,418.8	1,889,833.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,110,207.9	6,119,801.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	126,777.8	25,656.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,305,427.8	4,453,963.7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-1,068,442.1	1,691,493.3

#### 4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	28,531,164.3	25,248,410.8
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,853,835.8	3,010,586.2
Нийтлэг татварын бус орлого	2,853,835.8	3,010,586.2
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	25,677,328.5	22,237,824.6
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	28,402,731.7	24,938,148.7
УРСГАЛ ЗАРДАЛ	28,402,731.7	24,938,148.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24,542,972.3	22,865,827.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,257,644.0	14,645,671.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,559,347.3	1,713,438.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,422,075.4	1,709,922.5
Хангамж, бараа материалын зардал	2,059,354.7	929,132.5
Нормативт зардал	618,085.8	696,220.1
Эд хогшил, урсгал засварын зардал	271,600.5	276,635.6
Томилот, зочны зардал	492,256.4	164,287.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,320,466.3	2,313,620.0
Бараа үйлчилгээний бусад зардал	1,542,141.8	416,899.8
ТАТААС	7,952.0	0.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,851,807.4	2,072,321.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	128,432.6	310,262.2
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.0	0.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	122,563.9	281,984.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	122,563.9	281,984.0
Дотоод эх үүсвэрээр	122,563.9	281,984.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-122,563.9	-281,984.0
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	25.7	4,399.3
Бусад эх үүсвэр	25.7	20,779.2
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		
ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР		
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.0	16,379.9
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	5,894.4	32,677.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,944.2	14,838.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,838.6	47,516.1

**4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**  
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	29,234,975.7	0.0	29,234,975.7
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-136,248.0	0.0	-136,248.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	29,098,727.8	0.0	29,098,727.8
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-1,570.9	0.0	-1,570.9
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	143,028.6		143,028.6
Тайлант үеийн үр дүн	-1,068,442.1	0.0	-1,068,442.1
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	28,171,743.4	0.0	28,171,743.4
2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	28,171,743.4	0.0	28,171,743.4
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	132,928.6	0.0	132,928.6
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	28,304,672.0	0.0	28,304,672.0
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	7,944,788.8	0.0	7,944,788.8
Тайлант үеийн үр дүн	1,691,493.3	0.0	1,691,493.3
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	37,940,954.1	0.0	37,940,954.1

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	21,597,249.6	21,249,274.2	347,975.4	98.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	21,597,249.6	21,249,274.2	347,975.4	98.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,231,532.8	20,884,387.6	347,145.2	98.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,621,640.8	14,518,743.4	102,897.4	99.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,711,950.5	1,703,146.1	8,804.4	99.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,733,984.9	1,683,820.2	50,164.7	97.1
2104	Хангамж, бараа материалын зардал	570,128.2	561,796.0	8,332.2	98.5
2105	Нормативт зардал	713,611.2	679,498.8	34,112.4	95.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	290,161.3	275,490.3	14,671.0	94.9
2107	Томилолт, зочны зардал	78,407.7	73,461.5	4,946.2	93.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,500,792.5	1,377,768.9	123,023.6	91.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,855.7	10,662.4	193.3	98.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	365,716.8	364,886.6	830.2	99.8
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	21,597,249.6	21,292,328.0	304,921.6	98.6
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	19,984,062.0	19,532,504.1	451,557.9	97.7
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,613,187.6	1,759,823.9	-146,636.3	109.1
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	7,197.7	-7,197.7	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	40,350.2	-40,350.2	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	3,269	3,269	-	100
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	33	33	-	100
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,618	1,618	-	100
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1,618	1,618	-	100

## 5 Хавсралт

### 5.1 Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт

<b>Огноо:</b>	<b>Аудитын нэр:</b>	<i>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит</i>	
2019/03/23		<b>Аудитын код:</b>	САГ-2019/21/СТА-ТТЗ
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар		<b>сая төгрөгөөр</b>

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл		Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Огноо	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5	6
1	Өмнөх оны давсан орлогын авлагаар тооцож төвлөрүүлсэн 80.3 сая төгрөгийг өөрийн хөрөнгө оруулалтад зарцуулаагүй 64.0 сая төгрөгийн үнэ бүхий Ниссан тийна маркын автомашин худалдан авч ХНХЯ-нд шилжүүлсэн	64.0	Зөвлөмж	2019.03.23	Дарга Нягтлан бодогч	Б.Нямдаваа Г.Оюун
2	2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар Хязгаарлалттай санал дүгнэлт болон зөрчил арилгах албан шаардлага авсан Санхүү, төлөвлөлтийн газрын дарга, ХЭДС-гийн нягтлан бодогч нарт 1 сарын үндсэн цалингаар урамшуулал олгосон	0.7	Төлбөрийн акт	2019.03.23	Нягтлан бодогч	Б.Оюунбилэг
3	Тайлант хугацаанд гадаад болон дотоод албан томилолтод нийт 95.6 сая төгрөг зарцуулснаас томилолтын зорилгод хамааралгүй албан тушаалтан явуулсан, нэг чиглэлд олон удаагийн томилолт гарсан, БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар явж буй иргэдийг хүргэж өгөхөөр Сангийн яам болон бусад аймаг нийслэлийн харьяа газруудын дарга нар томилолтоор явсан	10.7	Зөвлөмж	2019.03.23	Дарга Нягтлан бодогч	Б.Нямдаваа Г.Оюун
Нийт		75.4				

Утас: +976 51 261585  
Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: [info@audit.gov.mn](mailto:info@audit.gov.mn)  
Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Хаяг: Засгийн газрын IV байр  
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг  
Улаанбаатар-15160, Монгол Улс